

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН
ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**

2022.12.12

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хувь
Нэг: Төсвийн тухай хууль, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд:							
1.1	Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжихээр заасан дараах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор зохион байгуулах;	-	Тендер зохион байгуулсан төсөл, арга хэмжээний тоо	6	12	2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 11.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 төсөл арга хэмжээ эрх шилжиж ирсэн бөгөөд 12 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж 11 төсөл арга хэмжээнд гэрээ байгуулах эрх олгоод байна. 2022 оны төсвийн тодотголоор “Шаардлага хангасан сайжруулсан түлшний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх /Дундговь/” төсөл арга хэмжээний төсөв татагдсан тул худалдан авах ажиллагааг захиалагчаас зогсоосон. “Дундговь аймгийн агаарын чанарыг сайжруулах бүсэд байрлаж буй улсын сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилгын дулааныг газрын гүний дулаан ашиглан шийдвэрлэх судалгаа, шинжилгээ, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах нь”, “Цөлжилтийг бууруулах зориудаар ойжуулах, байгалийн сэргэн ургалтыг нэмэгдүүлэхэд шаардлагатай зардалд дэмжлэг үзүүлэх /Дундговь/” зэрэг төсөл арга хэмжээний зураг төсвийг ирүүлээгүй тул худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй байна. Тус төсөл арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг 2022 оны 03 сарын 01-ний өдрөөс өмнө зарлан зохион байгууллаа.	100
1.2	Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим	-	2022 онд өр, авлагын хэмжээг	0	0	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн төсвийн зарлагын гүйлгээнд тавих хяналтыг чангатгаж төлбөр тооцоог хуулийн хугацаанд	100

	арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолын дагуу төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллах чиглэлийг баримтлан тогтоолд заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах		нэмэгдүүлээгүй байх			гүйцэтгэн, өр авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулан ажилласны үр дүнд энэ онд шинээр нэмэгдсэн урсгал зардлын өр төлбөргүй байна. Өмнөх онуудад бий болсон хугацаа хэтэрсэн дамжуулан зээлийн өр, халаалтын зардлын өр төлбөрөөс 357,6 сая төгрөгийг төлж барагдууллаа.	
Хоёр. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх хүрээнд:							
2.1	Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулах;	-	Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн хувь	73	80	Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 82.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Шалгуур үзүүлэлтийн дагуу аймгийн нэгдсэн сайт www.dundgovi.gov.mn сайтын “Ил тод байдал” цэс болон мэдээллийн самбарт нээлттэй мэдээлэх мэдээ мэдээллийг байршуулан олон нийтэд хүргэж байна.	100
			Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	91.7	92.3	Аймгийн ЗДТГ-ын 2022 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээг иргэд, олон нийт, аймгийн төлөөлөгч нараас ирүүлсэн саналын дагуу 14 зорилт, 60 арга хэмжээтэй төлөвлөн боловсруулж, 92.8 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлаг, сумдад дүгнэх хуудасны хамт хүргүүлэн сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарт уг төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлж ажиллах талаар арга зүйн семинар, сургалтыг зохион байгуулан ажилласан.	
2.2	1.2.1. Төрийн цаасан суурьтай үйл ажиллагааг багасган цахим хэлбэрт шилжүүлж, төрийн үйлчилгээний шат дамжлагыг багасгах, чанар, хүртээмжийг сайжруулах;	-	Төрийн үйл ажиллагааг цахимд шилжүүлсэн тоо	0	64	Орон нутгийн шинж чанартай 64 үйлчилгээг “И-Монголиа” төрийн цахим үйлчилгээний системд нэвтрүүлсэн.	100

2.3	Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг сайжруулан, үр ашгийг нэмэгдүүлэх, орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах;	-	Орлого төвлөрүүлэх хувь	85	90	Орон нутгийн өмчит 25 хуулийн этгээдийн 199 түрээсийн гэрээг баталгаажуулж, жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсөвт 19.5 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлж, орон нутгийн өмчит байгууллагын акталсан хөрөнгө, барилга, их засвараас гарсан материалыг худалдан борлуулахад хяналт тавьж, жилийн эцсийн байдлаар орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд 47.7 сая төгрөг төвлөрүүлээд байна. Нийт орон нутгийн орлогын дансанд 67.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн ажилласан бөгөөд орлого төвлөрүүлэлт 95 хувьтай байна. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2022 оны улсын үзлэг тооллогыг Дундговь аймагтаа амжилттай зохион байгууллаа. Тооллогын хүрээнд орон нутгийн өмчит нийт 142 хуулийн этгээдийн улсын тооллогын үйл явцад хяналт тавьж, газар, үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгслийг нүд үзэж тоолон, хөрөнгийн хадгалалт хамгаалалт, агуулахын эмх цэгц үзэж шалган, ашиглалтгүй байгаа хөрөнгийг ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах талаар анхаарч ажиллахыг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, өмч хамгаалах зөвлөлд анхааруулж, зөвлөмж өгч ажиллалаа.	100
-----	---	---	-------------------------	----	----	---	-----

2.4	Нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийг оновчтой хуваарилах, ажил, үүргийн давхардлыг арилгах;	-	Байгууллагын чиг үүргийг оновчтой хуваарилсан эсэх Тийм-1, үгүй-0	1	1	Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377 дугаар тогтоолын дагуу аймгийн ЗДТГ-ын хэлтэс, албан хаагчдын чиг үүрэгт “Аргачлал батлах тухай” Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу аймгийн ЗДТГ-ын даргын 2022 оны А/70 дугаар тушаалаар чиг үүргийн шинжилгээ хийх ажлын хэсгийг байгуулан чиг үүргийн шинжилгээ хийж, аймгийн Засаг даргын 2022 оны А/20 дугаар “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоо батлах тухай” захирамжаар бүтэц орон тоог шинэчлэн чиг үүргийн давхардал, хийдэл үүсгэхгүйгээр оновчтой зохицуулалт хийн 16 төрийн жинхэнэ албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулан Төрийн албаны зөвлөлөөр батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.	100
2.5	2.2.4. Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгох;	ОНТ 40,0	Төрийн албан хаагчийг чадавхжуулах сургалтад хамруулах	-	150	Аймгийн Засаг даргын захирамжаар 2022 оныг “Хүний хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Дундговь аймгийн Төрийн албан хаагчид түүнчлэн боловсрол, соёл, эрүүл мэнд, эрдэм шинжилгээний болон бусад салбарт солилцоо, хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд Глобал удирдагч Их сургуультай хамтын ажиллагааны гэрээ байгуулан хамтын ажиллагааны хүрээнд орон нутгийн 160 төрийн албан хаагчийг хөнгөлөлттэй нөхцөлөөр магистрын сургалтад хамрууллаа. Удирдлагын академийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад 13, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 20, төрийн албанд анх томилогдсон иргэнийг мэргэшүүлэх сургалтад 10, “Алсын хараа-2050” зайн сургалтад 8, “Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааны зохицуулалт, шинэчлэлт” зайн сургалтад 10, “Төрийн байгууллага дахь харилцаа, маркетинг” зайн сургалтад 9 хүн Аймгийн ЗДТГ-ын дарга нарт зориулсан “Нутгийн захиргааны	100

						байгууллагын удирдлага зохицуулалт” сэдэвт богино хугацааны зайн сургалтад 11, үр дүнд суурилсан удирдлага сэдэвт богино сургалтад 4 албан хаагч нийт 85 хүнийг богино болон дунд хугацааны сургалтад хамрууллаа.Ингэснээр аймгийн хэмжээнд нийт 131 төрийн албан хаагч богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна.	
			төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгууртай эсэх /тийм-1, үгүй-0/	1	1	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын 9 дүгээр хавсралтын дагуу тус аргачлалын 3 дугаар бүлэгт заасан шалгуурын дагуу төрийн албан хаагчийн ёс зүй, ур чадварын үнэлгээний батлагдсан маягтын дагуу үнэлэн дүгнэж байна.	
2.6	Орон нутагт нийтийн биеийн тамирыг дэмжих орчныг бүрдүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл идэвхтэй амьдралын хэв маяг, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, өсвөр үеийн шигшээ баг, тамирчин, дасгалжуулагчдыг бэлтгэн холбогдох спортын наадам, тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулах, оролцуулах эх үүсвэр болон спорт, нийтийн биеийн тамирын зориулалтын барилга, цогцолборын үйл ажиллагааг хэвийн явуулах зардлыг шийдвэрлэх;	-	Иргэдэд үнэ төлбөргүй заалаар үйлчилсэн цаг	-	500	2022 оны 02 дугаар сарын 15 ны өдрөөс 05 дугаар сарын 30 ны өдөр хүртэл буюу нийт 105 өдөр өглөө 06:30-09:00 цаг, өдөр 12:00-14:00 цаг хүртэл нийт 472,5 цаг иргэдэд үнэ төлбөргүй заалаар үйлчилсэн. Мөн 1990 оноос 1999 оны төгсөгчдийн тэмцээн, “Хүмүүнлэг” сургууль төгсөгчдийн тэмцээн, “Говийн ирээдүй” цогцолбор сургууль төгсөгчдийн тэмцээн, төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан 6 удаагийн тэмцээн, салбарын байгууллагуудын тэмцээнд оролцох 9 байгууллагын ажилчдын бэлтгэл сургуулалтыг хийлгэх зэрэг 20 гаруй үйл ажиллагааг үнэ төлбөргүй зааланд зохион байгуулсан. Сайнцагаан суманд сагсан бөмбөгийн хосолсон талбай 3, 3x3 сагсан бөмбөгийн талбай 1-ийг шинээр нэмэгдүүлж, иргэдийн нийтийн биеийн тамираар хичээллэх орчныг бүрдүүлэн, эрүүл идэвхтэй амьдралын хэв маяг, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлж байна.	100
		УТ 21.0	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	22	26	Өсвөр үеийн шигшээ багийг спортын 15 төрлөөр байгуулан бэлтгэл сургуулилалтыг ханган ажиллаж байна. Аймгийн спортын 17 клуб, холбоодтой хамтран, улс, бүс, аймгийн аварга	

						шалгаруулах, нэрэмжит зэрэг 83 уралдаан тэмцээнийг зохион байгуулж, нийт 28500 иргэнийг оролцуулсан. Мөн сагсан бөмбөгийн 5x5 3x3, үндэсний сур, шагайн харваа, хөнгөн атлетик волейбол, уран гимнастик жүдо зэрэг улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээнд баг тамирчдыг оролцуулаад байна.	
		ОНТ 439.1	Үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ	244632 600	300364 300	Спорт, нийтийн биеийн тамирын зориулалтын барилга, цогцолборын үйл ажиллагааг хэвийн явуулах урсгал засвар, гэрэл цахилгаан, халаалт, цэвэр бохир усны төлбөрт 439,1төгрөгийг зарцуулсан байна.	
2.7	Хотоос хөдөө рүү шилжин суурьшиж байгаа иргэн, өрх, хөдөлмөр эрхлэгч, аж ахуйн нэгжийг бүх талаар дэмжих зорилтыг дэвшүүлж, хэрэгжүүлэх, орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломжийг бүрдүүлэх;	-	Үйл ажиллагааг дэмжсэн эсэх Тийм-1 Үгүй -0	0	1	"Ид шидийн орон" хүүхэд хөгжил, хамгааллын төвийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын Тамгын газраас газар, дэд бүтцийн асуудлыг 100 хувь шийдвэрлэсэн бөгөөд тус төвд 55.4 сая төгрөгийг Засаг даргын нөөцөөс дэмжлэг үзүүлж, цаашид үйл ажиллагааны урсгал зардлыг бүрэн хариуцаж ажиллахаар болж, 2023 оны тогтмол болон үйл ажиллагааны зардал болох 230,0 сая төгрөгийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталлаа.	100
2.8	Аймаг, сумын төвүүдийн хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулах;		Шинээр байгуулагдсан дахивар нөөц авах цэгийн тоо	2	5	3 суманд ангилан ялгах цэг шинээр нэмэгдэж, Сайнцагаан суманд 8 тн, Сайхан-Овоо суманд 3.5тн, Дэлгэрцогт суманд 2.5тн, Луус суманд 3тн, нийт 4 суманд 3 төрлийн 17 тн дахивар хог хаягдлыг дахивар нөөц авах цэгтээ ангилж цуглуулсан.	66,6
2.9	Аймгийн төв, суурин газрын агаар, орчны бохирдлыг бууруулах, хөрсний доройтлоос хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх.	УТ 608,5	Шүүлтүүр байрлуулсан яндангийн тоо	-	8	БОАЖЯамнаас санхүүжүүлэн "Регал инженеринг" ХХК-тай гэрээ байгуулсны дагуу "Дундговь –Ус" ОНӨҮГ-ын 2 дугаар зууханд 3, "Тэвшийнговь" ХХК-ийн зууханд 1, "Ган-Илч" ХХК-ийн зууханд 4, нийт төвлөрсөн халаалтын 8 янданд утаа шүүгч байршуулах ажил хийгдсэн. Улсын төсвийн 608.5 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан.	100
Гурав. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх хүрээнд:							

3.1	Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолоор баталсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ”-г аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх;	УТХ 90,0 ОНТ 122,0 Хувийн хэвшил 116.3	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	90	Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 2 арга хэмжээ тусган Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, “Дундговio ногоорууль” хөтөлбөрийг 100 хувь хэрэгжүүлэн ажиллалаа	100
3.2	Аймгийн хэмжээнд мод тарьж, арчилж, ургуулах ажлыг нарийвчилсан судалгаа, төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулж, мод тарих үйл ажиллагаанд хувийн хэвшил, иргэд олон нийтийг оролцуулан мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх		Тарьсан модны тоо	62670	100000	“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, “Дундговio ногоорууль” хөтөлбөрийн хүрээнд “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг 2 удаа зохион байгуулж, 1053 өрх, 147 аж ахуйн нэгж, байгууллагын 5690 иргэнийг хамруулан мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Нийт 122884 мод, сөөг тарьж ургуулж байна. Улсын төсвөөр 90.0, орон нутгийн төсвөөр 122.0, хувийн хэвшлийн хөрөнгөөр 116.3 сая төгрөг зарцууллаа.	100
Дөрөв. Засаг дарга дараах үүргийг хүлээнэ:							
4.1	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, бусад хууль тогтоомж болон энэ гэрээгээр хүлээсэн төлөөлөн гүйцэтгэх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, үр дүнг Ерөнхий сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын өмнө хариуцах;	-	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласан эсэх Тийм-1, үгүй-0	1	1	Аймгийн Засаг даргаас 2022 онд 7 хоног бүрийн 1 дэх өдөр төрийн байгууллагын бүх шатны удирдах, гүйцэтгэх албан тушаалтанд Засаг даргын шуурхай хурлаар өөрийн хариуцсан ажлын хуулиар хүлээсэн эрх үүргээ хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа ард иргэдэд сурталчлах, тайлагнах ажлыг тогтмол зохион байгуулах талаар үүрэг чиглэл өгч ажилласан. Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон Захиргааны ерөнхий хууль, Төсвийн тухай бусад хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж, хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг давхардсан тоогоор нийт 431 заалтын хэрэгжилтийг гаргаж ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн. Хэрэгжилтийн дундаж 74,2 хувьтай байна.	100

4.2	Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар баталсан төсвийн орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, батлагдсан зардалд багтаан үйл ажиллагаагаа явуулах;	-	Орлогын төлөвлөгөөний биелэлт	112,0	100	Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт дөрөвдүгээр улирлын байдлаар 8565373,9 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 9460969,8 мянган төгрөг төвлөрч 110 хувийн гүйцэтгэлтэй байна. 1. Улсын төсвийн орлого 1453532,5 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 1734045,9 мянган төгрөг төвлөрч 119 хувь 2. Аймгийн төсвийн орлого 798673,6 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 1084353,5 мянган төгрөг төвлөрч 136 хувь 3. Сумын төсвийн орлого 6313167,8 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 6642570,4 мянган төгрөг төвлөрч 105 хувьтай байна.	100
4.3	Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжихээр заасан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцаас захиалагчийн эрх шилжүүлсэн 392.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж, төсөл, арга хэмжээний үе шат бүрд тавих техник хяналт, захиалагчийн хяналтыг холбогдох хууль, дүрэм журмыг баримтлан хариуцлагатай хийх;	-	Ашиглалт оруулсан төсөл, арга хэмжээний тоо	0	2	Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжихээр заасан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцаас эрх шилжүүлсэн “Засаг даргын тамгын газрын барилгын засвар /Дундговь, Дэлгэрцогт сум/” ажлын гүйцэтгэгчээр “Ашид бьюлдинг” ХХК, “Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж /Дундговь/” нийлүүлэгчээр “Тэлмэн нетворк” ХХК тус тус шалгарч гэрээ байгуулсан боловч төсвийн 2022.04.26-ны өдрийн тодотголоор төсөв татагдсан.	-
4.4	“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Шинэ сэргэлтийн бодлого”-д заасан арга хэмжээг тогтоосон хугацаанд нь үр дүнтэй	-	Хэрэгжилтийн хувь	-	80	“Алсын хараа 2050”-ийн хэрэгжилт 100 хувьтай Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 зорилтын 18 арга хэмжээний хэрэгжилт 93,5 хувьтай байна. “Шинэ сэргэлтийн бодлого”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл 70 хувьтай хэрэгжүүлэн ажиллалаа. Дээрх бодлогын баримт бичгүүдийн дундаж хувь 87,8 хувьтай байна.	100

	хэрэгжүүлэх;						
4.5	Ил тод, үр ашигтай төсвийн бодлогыг хэрэгжүүлж, энэ хүрээнд эдийн засгийн өсөлтийг дэмжиж, төсвийн сахилга батыг чанд баримтлан төсвийн алдагдал болон татварын дарамтыг бууруулах, өрийн дарамтыг багасгах, экспорт, импортын бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулж, төсвийн болон орон нутгийн сангуудын үйл ажиллагааг ил тод болгон, төсвийн үр ашгийг сайжруулж ажиллах;		Шилэн дансны хэрэгжилтийн хувь	96,0	96,5	2022 оны дөрөвдүгээр улирлын байдлаар Шилэн дансны тухай хуулийн дагуу орон нутгийн өмчит төсвийн байгууллага, ОНӨҮГ-ийн 102 байгууллага тогтоосон хугацаанд байршуулах нийт 12470 мэдээллээс 90 хувь буюу 11188 мэдээллийг хугацаанд нь, 7 хувь буюу 876 мэдээллийг хугацаа хожимдуулан цахим сүлжээнд байршуулан мэдээлж, нийт мэдээлэх мэдээний гүйцэтгэл 97 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажиллалаа.	100
4.6	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу ажлын үе шатны хяналтыг сайжруулан төлөвлөсөн хугацаанд дуусгах арга хэмжээ авах;	-	хяналтыг сайжруулан төлөвлөсөн хугацаанд дуусгасан эсэх Тийм-1, Үгүй-0	-	1	2022 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 18 тэрбум төгрөгийн 82 бараа, ажил, үйлчилгээний төсөл, арга хэмжээг худалдан авахаар төлөвлөсөн бөгөөд үүнээс тендер зарлах шаардлагатай 50 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж үүнээс 43 ажил энэ онд хэрэгжиж дууссан бөгөөд 7 ажил он дамжин санхүүжихээр 2023 оны орон нутгийн төсөвт суутгагдаад байна.	100
4.7	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (шинэчилсэн найруулга), түүнийг дагалдан гарсан хууль, тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх талаар тусгай төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллах;	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	80	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль түүнийг дагалдан гарсан хууль, тогтоомжийг иргэд, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчдад сурталчлан таниулах зорилгоор 10 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилт 85 хувьтай байна. Төлөвлөгөөний хүрээнд цахимаар болон танхимын хэлбэрээр эрх зүйн сургалтыг 12 удаа 557 хүнд, сурталчилгааг 3 удаа 490 гаруй хүнд зохион байгуулсан.	100

4.8	<p>“Коронавирустхалдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зөвхөн тухайн албан тушаалын тодорхойлолтын боловсрол, мэргэжил, туршлагын шаардлагыг хангасан иргэнийг томилно. Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан Төрийн албаны зөвлөлөөс зөвшөөрөл авч, албан хаагчийг сонгон шалгаруулах, албан тушаалд томилох, шатлан дэвшүүлэхдээ Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 2 дугаар тогтоолоор баталсан төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг баримталж ажиллах;</p>	-	Томилгооны зөрчилгүй ажилласан байх /Тийм-1, үгүй-0/	0	1	<p>Томилгооны зөрчилтэй томилогдсон 64 албан хаагчийн томилгооны зөрчлийг арилгуулах талаар арга хэмжээ авч хэрэгжилт 85.9%-тай байна. Аймгийн Засаг даргаас томилогддог Орон нутгийн өмчийн газар, Эрүүл мэндийн газар, Биеийн тамир спортын газрын дарга нарын томилгооны зөрчил арилаагүй. Нийгмийн даатгалын хэлтсийн бичиг хэрэг, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Мал эмнэлгийн газрын Өндөршил сум хариуцсан мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч 2 жирэмсний амралттай байгаа. Сумдын Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчдын хүний нөөцийн томилгоонд салбар зөвлөлийн гишүүд хяналт шалгалт зохион байгууллаа. Шалгалтаар илэрсэн 22 зөрчилтэй ажлын байрны судалгааг гарган томилгооны зөрчлийг 90.9% арилгууллаа. Хулд сумын ЗДТГ 2 албан хаагчийн томилгооны зөрчлийг арилгаагүй. Аймгийн нийт дүгээр Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 411 дүгээр тогтоолын хэрэгжилт 87.2%-тай хэрэгжлээ. Ингэснээр аймгийн хэмжээнд төрийн захиргааны албан хаагчийн томилгооны зөрчил 22.5% байсныг 2.8%-д хүргэж 19,7 хувиар бууруулсан байна.</p>	90
4.8.1	<p>Төрийн албан хаагчийг томилохдоо “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын зохицуулалтын дагуу зохист хэлбэрүүдийг ашиглан хууль зөрчихгүй ажиллана. Хууль зөрчсөн тохиолдол Төрийн албаны тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээх;</p>		Шатлан дэвшсэн албан хаагчийн тоо	-	Гүйцэтг элээр	<p>Төрийн албаны тухай хууль болон чадахуйн зарчим, шатлан дэвших тогтолцоонд нийцүүлэн 58 төрийн албан хаагчийг дэвшүүлэн ажиллуулсан нь нийт төрийн жинхэнэ албан хаагчийн 16.1 хувийг шатлан дэвшүүлэн ажиллуулсан байна.</p>	100
	Шилжин сэлгэн ажиллуулсан албан хаагчийн тоо	15	Гүйцэтг элээр	<p>Төрийн албаны тухай хууль болон Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журмын дагуу 18 төрийн албан хаагчийг шилжүүлэн, сэлгүүлэн ажиллууллаа.</p>			

4.9	Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариуг өгөх ажиллагааг нэг цэгээс шуурхай, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, шийдвэрлэлтэд ахиц дэвшил гаргах;		Нэг өргөдлийг судалж шийдвэрлэх дундаж хоног	30	28	Дундговь аймгийн нийт төрийн байгууллага, 15 сумдад иргэдээс санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг бичгээр, цахимаар, утсаар, хайрцгаар, биечлэн уулзах хэлбэрээр хүлээн авч, шийдвэрлэж хэвшсэн. 2022 оны гуравдугаар улирлын байдлаар аймгийн хэмжээнд нийт 3076 өргөдөл бүртгэснээс 2944 өргөдлийг хуулийн хугацаанд судалж 95,7 хувийн гүйцэтгэлтэй шийдвэрлэлээ. Өргөдөл гомдол хүлээн авах, бүртгэх, судалж, шийдвэрлэх явцад тогтмол хяналт тавьж ажилласны үр дүнд нэг өргөдлийг судалж шийдвэрлэх дундаж хугацаа 2021 онд 28 хоног байсан бол 2022 оны гуравдугаар улиралд нэг өргөдлийг судалж шийдвэрлэх дундаж хугацаа 27,2 хоног болж даруй 0,4 хоногоор багассан байна. 2134 өргөдөл тутамд судалж шийдвэрлэх хугацаа 0,4 хоногоор багассан нь иргэдийг чирэгдэлгүй, хүлээлт бага байлгах үндсэн үзүүлэлт юм.	100
4.10	Төрийн үйлчилгээг цахимжуулах ажлыг эрчимжүүлэн, төрийн үйлчилгээ-мэдээллийн төвийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, системийн сургалтын үйл ажиллагаанд холбогдох байгууллагын удирдлага, албан хаагчийг идэвхтэй оролцуулан, үйлчилгээний чанар, шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнах;	ГХО 20,0 ОНТ 1,2 сая	Төрийн үйлчилгээ-мэдээллийн төвийн үйл ажиллагаа тогтмолжсон эсэх тийм-1, үгүй-0 сургалтын үйл ажиллагаанд холбогдох байгууллагын удирдлага, албан хаагчийн оролцоог хангасан эсэх тийм-1, үгүй-0	-	1	“И-Монголиа” УТҮГ-тай хамтран “Цахим аймаг-Дундговь” нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа ерөнхий консулын газартай хамтран 20 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “И-Монголиа” үйлчилгээний цэгийг байгуулж үйл ажиллагааг тогтмолжуулан иргэдэд төрийн цахим үйлчилгээг үзүүлж байна. 185 үйлчилгээг 186,000 мянган удаа үйлчилгээ авсан байна. төрийн үйлчилгээний нэгдсэн системд 16222 мянган иргэн бүртгэлтэй байна.	100
				-	1	“И-Монголиа Академи” УТҮГ-тай хамтран төрийн байгууллагуудын дотоод удирдлагын цахим ERP системийн иж бүрэн сургалтыг зохион байгуулж, 192 албан хаагчийн хамруулсан. Мөн тус академийн сургалт хөгжүүлэлтийн албатай хамтран төрийн албан хаагчийн мэдээллийн технологийн чадавхыг нэмэгдүүлэх 2 удаагийн сургалтад 300 гаруй төрийн албан хаагчдын хамруулан зохион байгуулсан. Төрийн байгууллагуудын ажлын шуурхай байдлыг хангах, бодит цагийн горимд албан бичиг солилцох зорилгоор “Цахим Дундговь-Цахим албан хэрэг	

						хөтлөлт” аяныг 2 үе шаттайгаар зохион байгуулж, сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагууд нийт 41 байгууллагуудын дунд зохион байгуулж, аяны хүрээнд төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх цахим болон танхимын сургалтыг зохион байгуулж, нийт 144 төрийн албан хаагчийг хамруулсан. Мэдээллийн аюулгүй байдлын сургалтыг зохион байгуулж 87 албан хаагчдыг хамруулж гэрчилгээ олгож нийт сургалтад 728 төрийн албан хаагчдад цахим ур чадварын сургалтыг зохион байгууллаа.	
4.11	Албаны болон хувийн ажлаар гадаадад явахдаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт мэдэгдэж, удирдамж, хөтөлбөрөө батлуулж, зөвшөөрөл авч хэвших;		Удирдамж хөтөлбөрийн дагуу зөвшөөрөл авч явсан гадаад уулзалтын хувь	0	100	Аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат БНСУ, Япон улсад албан хэргээр зорчих удирдамжийг боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газраар батлуулан илтгэх хуудсыг хүргүүлсэн.	100
4.12	Хэрэг эрхлэх газрын удирдлагаас өгсөн үүргийг цаг алдалгүй шуурхай хэрэгжүүлж ажиллах.	-	өгсөн үүргийг цаг алдалгүй шуурхай хэрэгжүүлж ажилласан эсэх тийм-1, үгүй-0	1	1	Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлагаас өгсөн үүрэг даалгавар 47 ирснээс 45 бичиг шийдвэрлэгдэж, 2 бичиг судлагдаж байна. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 18 заалтын хэрэгжилтийг сар бүр, хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг нэгдүгээр улиралд 13 тогтоол 23 заалт, 2 дугаар улиралд 65 тогтоол шийдвэрийн 120 заалт, 7 дугаар сард 51 тогтоол шийдвэрийн 144 заалт, 8 дугаар сард 39 тогтоол шийдвэрийн 56 заалт, 19 тогтоол шийдвэрийн 31 заалт, 10 дугаар сард 17 тогтоол шийдвэрийн 28 заалт, 11 дүгээр сард 22 тогтоол шийдвэрийн 29 заалтын хэрэгжилтийг гарган ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлж ажилласан.	100
УТ-719.5, ОНТ -602.3, Хувийн хэвшил-116.3, ГХО- 20,0							1,458,1
Нийт 25 заалтын хэрэгжилт							98,2

БАТАЛГААЖУУЛСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ТҮВШИНЖАРГАЛ

НЭГТГЭСЭН:
НУТГИЙН ЗАХИРГАА, ТАЙЛАН МЭДЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.ПЭРЭНЛЭЙМАА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э. ОДОНЧИМЭГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2022.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт			
		Зарцуулсан хөрөнгө	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/
Нэг:гэрээний заалтын хүрээнд:					
1.1	Арга хэмжээ				Хүрсэн түвшин буюу арга хэмжээний хэрэгжилтийг бичнэ. Хэрэгжилтийн хувь
1.2	Арга хэмжээ				
1.2					